

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1.Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2.Төслийн хүчин чадал, агуулахын төлөвлөлт	4
1.3.Төслийн үндсэн бүтээгдэхүүн	6
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
2.1. Физик газарзүй, ландшафт.....	7
2.2. Газрын гадарга, геоморфологи.....	7
2.3. Цаг уур, уур амьсгалын төлөв байдал.....	8
2.4. Гадаргын болон газрын доорх усан орчин	14
2.4.1. Гадаргын ус.....	14
2.4.2. Газрын доорхи ус.....	16
2.5. Хөрсөн бүрхэвч	17
2.6. Ургамалан нөмрөг.....	18
2.7. Амьтны аймаг.....	20
2.8. Нийгэм, эдийн засгийн төлөв байдал.....	21
Эдийн засгийн байдал.....	22
ХАА-н үзүүлэлт	22
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	23
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН	27
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	27
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)	29
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)	33
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)	34
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)	37
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	41
АРВАННЭГ.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	43
АРВАНХОЁР.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)	44

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Химийн болон тэсрэх бодисын нэр, хэмжээ	6
Хүснэгт 2. Нарны гийгүүлэлийн үргэлжилсэн дундаж хугацаа /цаг/	9
Хүснэгт 3. Агаарын чанарын индексийн ангилал ба хүний эрүүл мэндэд үзүүлэх	13
Хүснэгт 4. Хоногт орсон 1 хувийн хангамшил бүхий хур бороо	15
Хүснэгт 5. Усны хатуулаг чанарын ангилал	16
Хүснэгт 6. Ханбогд сумын хүн ам, өрхийн тоо	22
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	23
Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь	24
Хүснэгт 9. Төслийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт	25
Хүснэгт 10. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа	26
Хүснэгт 11. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл	26
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	33
Хүснэгт 14. Үүсэх хог хаягдлын химийн бодисын жагсаалт	37
Хүснэгт 15. Аюултай хог хаягдлын жилд үүсэх хэмжээ	37
Хүснэгт 16. Химийн аюултай, хортой бодисын хуванцар сав, полипропилен уут, шуудай, баглаа боодлыг дахин боловсруулах байгууллагын мэдээлэл	38
Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	39
Хүснэгт 18. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	34
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	42
Хүснэгт 20. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт	43
Хүснэгт 21. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь	44
Хүснэгт 22. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн	45

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Агуулахын тойм зураг	3
Зураг 2. Эмульсийн тэсрэх бодисын	4
Зураг 3. Эмульсийн тэсрэх бодисын агуулахын гадна болон доторх байдал	5
Зураг 4. Ландшафтын бүс, мужлалтын зураг	7
Зураг 5. Монгол орны геоморфологийн зураг	8
Зураг 6. Цэлмэг, бүрхэг өдрийн тоо	9
Зураг 7. Ханбогд сумын уур амьсгалын климаграмм	9
Зураг 8. Агаарын температурын экстрем утгууд	10
Зураг 9. Агаар болон хөрсний температурын хоорондын хамаарал	10
Зураг 10. Хур тунадасны жилийн хуваарлагдалт	10
Зураг 11. Агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ	11
Зураг 12. Салхины дундаж хурдны өөрчлөлт /2010-2020он/	11
Зураг 13. Салхины зонхилох чиглэл	12
Зураг 14. Агаарт агуулагдах бодисын хэмжээ	12
Зураг 15. Агаар дах том ширхэглэгт тоосонцорын жилийн агууламж	13
Зураг 16. Ханбогд сумын агаарын чанарын индекс	14
Зураг 17. Монгол орны гол мөрний ай сав (а) ба голын сүлжээний нягтшил (b)	14
Зураг 18. Гидрогеологийн мужлал	15
Зураг 19. Зуны хур бороо (а) болон хаврын шар усны (b) үерийн хамгийн их урсац, мм	15
Зураг 20. Монгол орны усны кальцийн ионы агууламжийн тархац, мг/л	16
Зураг 21. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг	17
Зураг 22. Ханбогд сумын ургамалжил	18
Зураг 23. Бэлчээрийн төрх байдал	19
Зураг 24. Ургамлын амьдралын хэлбэр	19
Зураг 25. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал	20
Зураг 26. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай	20
Зураг 27. Говийн амьтад	21

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор”

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Орика Монголиа” ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9019003068, Регистрийн дугаар: 2866838)

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, Гурван гол оффисын байр, 3 давхар (Утас: 329043)

Төслийн зорилго: Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагад нийцсэн эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх, хадгалах зорилготой. Эмульсийн тэсрэх бодисыг Оюутолгой уурхайд ашиглах бөгөөд үйлдвэрлэх түүхий эд нь химийн бодис юм. Үйлдвэрт 20 төрлийн химийн бодис ашиглана.

Төслийн ач холбогдол: Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгойн уурхай, тэнд ажиллаж байгаа 15000 гаруй ажилтнууд, улмаар төсвийн чухал орлогыг бүрдүүлэгч зэсийн хүдрийн экспортыг тасалдуулахгүй байх ач холбогдолтой төсөл юм.

Төслийн талбайн байршил: Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх Оюу Толгой уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг.

Газрын зөвшөөрөл: Ханбогд сумын засаг даргын 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 28 тоот шийдвэрийг үндэслэн 151100104 нэгж талбарын дугаартай 8489.092 га газрыг 5 жилийн хугацаатай газрыг уул уурхайн зориулалтаар авсан. Засаг даргын 2016 оны а/74 тоот шийдвэрээр 2036 оны 03 сарын 23-ний өдөр хүртэл 20 жилийн хугацаатай сунгасан болно.

Зураг 1. Агуулахын тойм зураг




1.2. Төслийн хүчин чадал, агуулахын төлөвлөлт

Тэсрэх бодисын үйлдвэр нь химийн бодисын агуулах, үйлдвэрийн барилга, тэсрэх бодисын агуулах зэргээс бүрддэг. Тэсрэх бодисын үйлдвэрийн байгууламжийн онцгой хамгаалалтын зурвас бүхий барилга байгууламжийг 2011 оны 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барьж ашиглалтад оруулсан. Тэсрэх бодисын үйлдвэр нь Оюу толгойн уурхайн лицензийн талбай дотор тусдаа 215м х 175м талбайтай хашаан дотор байрладаг. Үйлдвэрийн барилга нь 35м х 28м хэмжээтэй ба химийн бодис хадгалах 42м х 30м хэмжээтэй 2 байгууламжтай.

Бүтээгдэхүүн нийлүүлэлт: “Орика Монголиа” ХХК нь БОАЖЯ-наас 2020 оны 8 дугаар сарын 23-ны өдөр 3 жилийн хугацаагаар авсан “Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд 20 төрлийн химийн бодис, бүтээгдэхүүнийг Замын-Үүд, Алтанбулаг боомтоор оруулж ирнэ. Үүний тулд Сингапур улсын “Орика Сингапур” компанитай химийн бодис худалдан авах ОМ-OSPL-01/2020 тоот гэрээг байгуулсан. Химийн бодисуудаа Хятад, Канад, Орос, Австрали улсаас, Тэсэлгээний хэрэгслээ Хятад, Канад, Казакстан, Филиппин улсаас авдаг.

Бүтээгдэхүүн борлуулалт: “Орика Монголиа” ХХК-ний импортлосон бүтээгдэхүүний гол хэрэглэгчид нь Оюу толгойн уурхай байх ба борлуулалтын үеийн тээвэрлэлт нь бараа худалдан авагчид өөрсдийн техникээр татан авах нөхцөлтэй байх болно.

Бүтээгдэхүүн тээвэрлэлт: Багахангай дүүрэгт байрлах агуулахаас Оюу Толгой уурхайн эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хэрэглээнд шаардагдах түүхий эд, хэрэгслийг дараах маршрутаар тээвэрлэнэ. Түүхий эд, ачаа бараа буулгах ажлыг тээврийн компаниудтай хамтран хийхээр гэрээ байгуулсан. Зуунмод сум-Дэлгэрцогт сум-Мандалговь сум-Цогтцэций сум-Оюу Толгой уурхай дахь үйлдвэр, агуулах гэсэн маршрутаар тээвэрлэнэ.



Зураг 2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн түүхий эд тээвэрлэх маршрут

Агуулахын бэлэн байдал: Эмульсийн тэсрэх бодисыг 300 м² талбай бүхий агуулахад хадгална. Агуулах нь химийн бодис хадгалах зориулалтын тавиуртай, зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх салхивчтай, хана, шал нь химийн бодис хадгалахад тэсвэртэй материалаар хийгдсэн, 24 цагийн харуул хамгаалалттай, төмөр хашаатай байна. Ажлын байранд гар болон нүд угаах төхөрөмжтэй. Агуулахад хадгалах химийн бодисыг монгол болон олон улсын нэр томъёо, CAS дугаар, тоо хэмжээг бүртгэсэн, эрүүл мэндэд нөлөөлөх зэрэглэл, галын хэрэгсэл, хор аюулын тэмдэглэгээ, урвалд орох зэрэглэлээр ангилан хадгалсан, химийн бодистой харьцан ажиллах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан ашиглалтын явцад мөрддөг, аюулгүй ажиллагааны дохио, санамж тэмдэглэгээнүүдлийг байрлуулсан бөгөөд шаардлагатай үед хэрэглэх нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангасан байна. Химийн бодис хадгалах агуулах нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалахад тавигдах үндсэн шаардлага, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 3.2.1.6-д заагдсан шаардлага, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын холбогдох заалтад нийцэж байна. (2020.02.20 өдрийн 16/04/38/08 дугаартай МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт)

Зураг 3. Эмульсийн тэсрэх бодисын агуулахын гадна болон доторх байдал



1.3. Төслийн үндсэн бүтээгдэхүүн

“Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд 20 төрлийн химийн бодис импортлоно.

Хүснэгт 1. Химийн болон тэсрэх бодисын нэр, хэмжээ

№	Химийн бодисын нэр төрөл	нэгж	2023 хэрэглээ /ойролцоогоор/
1	Эмульсжүүлэгч SB120i	кг	276,663.20
2	Цууны хүчил /Acetic Acid/	кг	30,631.92
3	Тиомочевин /Thiourea/	кг	30,241.20
4	Натрийн карбонат /Soda Ash/	кг	223.96
5	Натрийн Нитрит /Sodium Nitrite/	кг	28,314.00
6	Гликол /Glycol/	кг	660.00
7	Эмульсжүүлэгч FBHP90 UG	кг	200,376.00
8	Мочевин /Urea/	кг	918,016.00
9	Эмульсжүүлэгч E2170T	кг	87,296.00
10	Аммиакийн шүү	кг	22,390,940.00
11	SB301 C surfactant blend	кг	66,000.00
12	E2170T Emulsifier	кг	220,000.00
13	Sorbiatan Mono oleate	кг	66,000.00
14	Magnesium Nitrate	кг	6,600.00
15	Calcium Nitrate	кг	6,600.00
16	Tartrazine yellow	кг	88.00
17	CI Acid Yellow 73	кг	88.00
18	Automate Red IK	кг	88.00
19	Brilliant Blue FCF	кг	88.00
20	Paraffin oil	кг	198,000.00

Ажиллах хүч: Нийт 5 хүн ажиллана.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


2.1. Физик газарзүй, ландшафт

Ханбогд сум нь Өмнөговь аймгийн нутгийн зүүн урд хэсэгт Даланзадгад хотоос 250 км, Галбын уулын ар бэл дээр Их булаг хэмээх газар байрлах ба энэ нь далайн түвшнээс дээш 1120 м өндөрт оршино.

Тус сум нь хойд талаараа Манлай, зүүн талаараа Дорноговь аймгийн нутагтай, урд талаараа Монгол, Хятадын 703-р хилийн цэгийн ойролцоо оршдог бөгөөд газарзүйн солбилцолын хувьд хойд өргөрөг $42^{\circ}24'6''$, зүүн уртраг $107^{\circ}34'34''$, Улаат дунд хошууны захиргаа байрладаг Халиут тосгоноос 133 км, Хятадын баруун хэсгийн зам харилцааны гол цөм болсон Бээжин, Төвдийн төмөр зам, өндөр хурдны замаас 220 км-т оршдог.

“Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах байрлах орчин нь физик газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Дорнод говийн муж, Дорнод говийн хотгорийн тойрогт (МУ-ын Үндэсний атлас, 2009), байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрогт хамаарна.

Зураг 4. Ландшафтын бүс, мужлалтын зураг




Эх үүсвэр: ГЗБГЗЗГ, ГЗБ- мэдээллийн архив

2.2. Газрын гадарга, геоморфологи

Төсөл хэрэгжих орчин нь гадаргуугийн хэлбэр дүрсээрээ Монгол орны геоморфологийн мужлалаар Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн тойрогт хамаарах ба гарал үүслээрээ тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дундах хотгор дахь элэгдэлийн гаралтай өргөдмөл гадарга болон голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадаргуу бөгөөд нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уулсын цав толгод голын хурдаст тал зонхилно (Зураг 5, МУ-ын Үндэсний Атлас, 2009).

Зураг 5. Монгол орны геоморфологийн зураг



Эх үүсвэр: ГЗБГЗЗГ, Геологи орчны мэдээллийн сан, архив

Газарзүйн нөхцөлийн хувьд энэхүү газар нутаг нь Монгол Улсын өмнөд хэсэгт улсын хилийн орчимд урдаас хойш сунаж тогтсон нам уулс, тал хөндий бүхий говь цөлийн бүсэд хамаарагдах бөгөөд далайн түвшнээс дээш 1000-1136.9 хүртэлх метрийн өндөрт өргөгдсөн гүвээ, жижиг толгодорхог талархаг газар байна. Тухайн нутагт хамгийн өндөр цэг нь Баруун тогоо овоо (1136.9 м), хамгийн нам цэг нь Цагаан хадын худаг (1014.0 м) юм. Мөн тэр орчимд Далан шар уул (1113.6 м), Гурван Зээрд уул (1100.0 м), хил дээрх Хар хушууны овоо (1095.2 м), тэр орчмын 1086.4м, 1069.0м зэрэг тоот өндөрлөг бүхий нам уул толгод бий. Нам уулын баруун хойт хэсэгт Зээрдийн худаг байх ба түүний баруун урд хэсгээр далайн түвшнээс дээш 1025.4 метрийн өндөртэй, эх чулуулгын илэрц бүхий толгой байх ба харин Зээрдийн худгийн зүүн хойт талд д.т.д 1087.4 метрийн өндөр бүхий толгодуудтай.

2.3. Цаг уур, уур амьсгалын төлөв байдал

Ханбогд сум нь цаг уурын хувьд зундаа +40 хэм хүртэл халж, өвөлдөө -15-25 хэм хүрч хүйтэрдэг байгалын эрс тэс уур амьсгалтай. Монгол Улсын хамгийн дулаан цэгт тооцогддог газар нутагтай сум юм.


2.3.1. Нарны цацраг

Төслийн бүс нутгаар нарны нийлбэр цацраг жилд дунджаар 1595-1610 квт.цаг/м² байдаг. Уур амьсгалын мужлалаар монгол орны хамгийн дулаан бүсэд хамаарагддаг бүс нутаг учир бусад сумдын нутгаас цэлмэг өдрийн тоо харьцангуй их, хуурай, чийгийн нөөц багатай хөрсөн бүрхэвч зонхилдог учир бүрхэг өдөр тун ховор тохиодог.

Хүснэгт 2. Нарны гийгүүлэлийн үргэлжилсэн дундаж хугацаа /цаг/

Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
2016	201.8	241.1	259.4	310.7	375.9	400.7	430.8	431.9	390.4	350.1	280.4	210.3
2017	209.7	224.7	249.1	310.6	360.7	410.8	450.9	440.1	389.3	360.9	291.7	221.7
2018	211.8	227.4	253.4	287.4	325.4	425.1	465.7	500.1	450.7	389.3	300.3	219.1
2019	200.3	210.9	237	250.6	285.3	415.9	441.3	487.2	440.4	380.4	299.4	200.3
2020	213.6	225.3	257.7	280.3	320.1	390.7	460.1	459.7	380.7	320.9	268.1	201.8

Зураг 6. Цэлмэг, бүрхэг өдрийн тоо




Тус бүс нутгаар бүрхэг өдрийн тоо дулааны улиралд дунджаар 2-4 өдөр, хүйтний улиралд цэлмэг өдрийн тоо олон жилийн дунджаас 4.5 %-иар ахиу байдаг байна. /өжд-аар цэлмэг өдрийн тоо 6-8 өдөр/


2.3.2. Агаарын температур

Тус нутгаар 6-р сарын эхэн үеээс 8-р сарын сүүл хүртэл агаартаа 30 градусыг давж халдаг бол хүйтний улиралд буюу 1-р сард агаарын үнэмлэхүй хүйтэн температур ажиглагддаг байна. Сүүлийн 10-н жилд агаарын үнэмлэхүй дулаан экстрем утга 2014 оны 7-р сарын 17-нд агаарт +41 градус хүрч халсан нь олон жилийн дунджаас даруй 4-9 градусаар дулаарсан байна.

Зураг 7. Ханбогд сумын уур амьсгалын климаграмм




Зураг 8. Агаарын температурын экстрем утгууд



Бүс нутгийн хөрсний дундаж температур I болон XII сард хамгийн хүйтэн байдаг бөгөөд VI, VII сард хөрсний температур хамгийн их байдаг. Үүнээс үзэхэд хөрсний температур эрс өөрчлөлттэй байдаг нь харагдаж байна. Хөрс нь өвлийн улиралд гүн рүүгээ дулаан, харин зуны улиралд гүн рүүгээ хүйтэн байдаг урвуу зүй тогтол ажиглагдаж байна. Хөрсний гадаргын температур нь агаарын температураасаа жилийн бүх хугацаанд 10-15 градусын хооронд хэлбэлзэж байдаг.

Зураг 9. Агаар болон хөрсний температурын хоорондын хамаарал




Ханбогд сумын хувьд хөрс нь сийрэг, элсэрхэг учир 5-9-р саруудад хөрсний гүндээ дулаан хангамжийн нөөц ихтэй байдаг. Харин хүйтний саруудад агаарын температураас даруй 3-10 градусаар хүйтэн байдаг зүй тогтолтой.

2.3.3. Хур тунадас

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ 98.5-160 мм байна. Харин жилдээ дунджаар 10 хоног цас ордог. Олон жилийн дунджаар жилдээ дулааны улиралд 80.5-112.1 мм ордог ба жилд орох хур тунадасны 96.8% нь дулааны улиралд буюу VI, VII, VIII сард ордог.

Зураг 10. Хур тунадасны жилийн хуваарлагдалт




Ханбогд сумын хувьд дулааны саруудад түр зуурын, хэдхэн минутаар үргэлжилсэн усархаг бороо орох нь элбэгшиж байна. Харин хүйтний улиралд 1 болон 12-р саруудад хур тунадасны хэмжээ олон жилийн дунджийн орчим байгаа нь өвлийн саруудад тогтвортой хүйтэн агаарын масс зонхилдогтой холбоотой юм.

2.3.4. Агаарын харьцангуй чийг

Агаарын чийгийн хэмжээ нь агаарын температур, хур тунадасны эрчимшилтэй шууд уялдаа холбоотой. Иймд тухайн газар нутгийн хөрсөн бүрхэвч болон чийгшлийн хэмжээг тодорхойлох нь уур амьсгалын бас нэгэн гол хүчин зүйлийн нэг юм.

Зураг 11. Агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ




Нэгдүгээр сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 30.0 хувиас доош, 7 сарын агаарын харьцангуй чийгийн дундаж нь 45.0 хувиас доош байдаг. Харин гантай зуны чийгийн давтагдал 40.0 хувиас доош бага байх үед гантай жил болдог. Тухайн жилд хур тунадас орох давтамж их байх тусам агаарт болон хөрсний чийгшлийн хэмжээ хангалттай түвшинд хүрдэг, шууд хамааралтай юм.

2.3.5. Салхины чиглэл болон хурд

Ханбогд суманд жилийн аль ч хугацаанд салхи ихтэй байдаг ба салхигүй өдрийн тоо сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүйтний улиралд 4-6 өдөр ажиглагддаг онцлогтой юм.

Зураг 12. Салхины дундаж хурдны өөрчлөлт /2010-2020он/



Салхины зонхилох чиглэл нь 3-5-р саруудад баруун зүгийн салхи, 6-9-р саруудад баруун өмнөдийн, 1-2, 10-12-р саруудад буюу хүйтний улиралд баруун хойдын салхи ажиглагдаж байна.

Зураг 13. Салхины зонхилох чиглэл




Цаг уурын тодорхойлолтоор салхигүй өдөр гэдэг нь тухайн хугацаанд, хоногт салхины дундаж хурд 0 м/с байх үеийг хэлдэг. Салхигүй өдрийн тохиолдлын тоо нь агаар мандлын орчил урсгал, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүдтэй шууд хамааралтай.

2.3.6. Агаарын чанарын төлөв байдал


Өмнөговь аймгийн агаарын чанарыг хянах харуул нь өдөрт 2 удаа автоматаар хэмжилт хийдэг ба агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий, азотын давхар исэл болон том ширхэглэгт тоос, тоосонцорыг шинжилдэг. Сүүлийн жилүүдийн шинжилгээгээр тус аймгийн агаарт хүхэрлэг хий болон азотын давхар исэл нь зөвшөөрөгдөх түвшнээс доогуур буюу агаарт маш бага хэмжээтэй агуулагддаг байна.

Зураг 14. Агаарт агуулагдах бодисын хэмжээ



Агаарт агуулагдах түгээмэл бохирдуулагчид болох Азотын давхар исэл болон Хүхэрлэг хийн хэмжээ хүлцэх хэм хэмжээнээс жилийн аль ч саруудад бага байдаг нь салхи ихтэй байдагтай мөн хүн амын суурьшил, дэд бүтэц хөгжил багатай байгааг илэрхийлж байгаа юм.

Зураг 15. Агаар дах том ширхэглэгт тоосонцорын жилийн агууламж /2012-2020 он/



Ханбогд сумын хувьд хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэх нөхцөл хомс байдагтай холбоотойгоор агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5, том ширхэглэгт тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ч сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Энэ нь газрын гадарга хэт хуурай, чийгийн нөөц харьцангуй бага байдаг зэрэг нутгийн хөрсний онцлогоос шалтгаалж байж болох юм.


Агаарын чанарыг индексээр 6 түвшинд ангилах (цэвэр, хэвийн, бага зэргийн бохирдолтой, дунд зэргийн бохирдолтой, их бохирдолтой, маш их бохирдолтой) бөгөөд түвшин тус бүрт харгалзах индексийн тоон үзүүлэлт (0-50, 51-100, 101-250, 251-400, 401-500, 501 <) өнгөт тэмдэглэгээ (ногоон, шар, улбар шар, ягаан, хүрэн, улаан), хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь ангилсан ангилалыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3. Агаарын чанарын индексийн ангилал ба хүний эрүүл мэндэд үзүүлэх ерөнхий нөлөөлөл

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Тэмдэглэгээ /өнгөөр/	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0-50	Цэвэр	Ногоон	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Шар	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно.
101-250	Бага зэргийн бохирдолтой	Улбар шар	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд, сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251-400	Дунд зэргийн бохирдолтой	Ягаан	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхлэнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401-500	Их бохирдолтой	Хүрэн	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл илэрнэ.
501 <	Маш их бохирдолтой	Улаан	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын агаарт хамгийн их агуулагдаж байгаа Хүхэрлэг хий болон Азотын давхар ислийн хэмжээгээр агаарын чанарын индексийг тодорхойлсон байдаг.

Зураг 16. Ханбогд сумын агаарын чанарын индекс




2.4. Гадаргын болон газрын доорх усан орчин

2.4.1. Гадаргын ус

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах орчимд түр зуурын урсгалтай гол горхи эсвэл тогтмол гадаргын усан сан байхгүй.

Монгол орны өмнөд хэсэг болох говь, цөл нь гадаргын усны ангиллаар, Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах /Зураг 17 (a)/ ба энд гол мөрний сүлжээний нягтшил 0,01 буюу түүнээс бага /Зураг 17 (b)/, хаврын шар ус, зуны хур борооны үед гадаргын түр урсац үүсгэх хуурай сайр, жалга бүхий бүс нутаг юм.


Зураг 17. Монгол орны гол мөрний ай сав (a) ба голын сүлжээний нягтшил (b)



a) 1-Хойд мөсөн далайн ай сав, 2-Номхон далайн ай сав, 3-Төв Азийн гадагш урсацгүй ай сав

Газрын доорхи усны тэжээлийн ангиллаар улирлын хомс тэжээл бүхий мужид багтана (Зураг 18).


Зураг 18. Гидрогеологийн мужлал



1. Түр зуурын элбэг тэжээлтэй, 2. Улирлын дунд зэргийн тэжээлтэй, 3. Улирлын хомс тэжээлтэй

Гадаргын урсац бүрдэх хэмжээ 0.01 л/с км² буюу түүнээс бага (Зураг 19). Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгалийн гамшигт үзэгдлийн тоо, давтамж, тэдгээрийн үргэлжлэх хугацаа, эрчимшил ихээхэн өөрчлөгдөж байгаа ба энэ байдал, манай оронд, хур борооны үргэлжлэх хугацаа богиносч, эрчимшил нэмэгдэх байдлаар илэрч байна. Монгол оронд, үерийн аюул үүсгэх хэмжээний борооны эрчимшил хоногт 40-120 мм байдаг. Говь, цөлийн бүсэд хур тунадас бага хэмжээтэй ордог ч маш аюултай уруйн үер үүсгэх хэмжээний бороо орж байсныг цаг уурын ажиглалтын мэдээнээс харж болно /Хүснэгт 4/.

Зураг 19. Зуны хур бороо (а) болон хаврын шар усны (б) үерийн хамгийн их урсац, мм



Хүснэгт 4. Хоногт орсон 1 хувийн хангамшил бүхий хур бороо

Д/д	Аймаг	Сум-өртөө	Ажиглалтын хугацаа	Ажигласан жилийн		
				Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
1	Өмнөговь	Ханбогд	1978-1990	42.7	7.0	21.1
2		Цогт-Овоо	1963-1990	42.0	7.7	17.0
3		Даланзадгад	1940-1989	138.0	7.4	25.7

Говь нутгийн газрын гадаргын өндөршлийн ялгаа төдийлөн их биш ч, өргөн хөндий тал ихтэй, хур борооны, ялангуяа үерийн үед их хэмжээний хохирол, сүйтгэл учруулж чадахуйц (усыг бодвол нягт ихтэй, эвдэх, сүйтгэх хүчин чадал өндөртэй) шавар, чулуун холимог бүхий уруйн үер эдгээр тод бус илрэх судаг, сайраар урсан ирэх магадлал өндөртэй.

Усны чанар


Монгол орны гол мөрний усны химийн найрлага бүрдэх үйл явцад зонхилох үүргийг тухайн сав газрын уулын чулуулаг, хөрс гүйцэтгэх ба говь, хээрийн бүсийн гол горхины

ус эрдэсжилт өндөртэй, гидрокарбонат, сульфат, карбонатын ангийн кальци-натрийн, эсвэл натри-кальцийн гэсэн холимог бүлэгт хамаарах ус зонхилох байр суурийг эзэлдэг. Усны хатуулаг нь, усанд агуулагдах кальци (Ca^{2+}), магни (Mg^{2+}), кальцийн карбонат (CaCO_3) зэрэг эрдэс бодисуудын хэмжээгээр тодорхойлогдох ба $[\text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}]$ ионуудын нийлбэрээр усны ерөнхий хатуулгийг илэрхийлнэ. Ерөнхий хатуулаг нь, [мг/л] (parts per million /ppm/) болон [мг-экв/л] нэгжээр илэрхийлэгдэнэ /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Усны хатуулаг чанарын ангилал

Д/д	Ангилал	мг-экв/л (Е.В.Посохов, $\text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$)
1	Маш зөөлөн	... < 1.5
2	Зөөлөн	1.5 – 3.0
3	Боломжийн хатуу	3.0 – 6.0
4	Хатуу	6.0 – 9.0
5	Маш хатуу	9.0 < ...

Зураг 20. Монгол орны усны кальцийн ионы агууламжийн тархац, мг/л



Монгол орны өмнөд хэсэг болох говь цөлийн бүс нутаг нь байнгын урсгал бүхий гол горхи байхгүй, зөвхөн хур тунадастай үед гадаргын түр урсац үүсэх хуурай сайр, жалгуудтай. Нэгэнт гадаргын ус ховор учир, хүн, малын ундны эх үүсвэр нь голын хуурай сайр болон баянбүрд бүхий нутгуудад, газрын өнгөн үе давхаргын усыг ашиглан гаргасан худгууд байдаг. Эдгээр газрууд нь зөвхөн хүн малын ундны усны эх үүсвэр болоод зогсохгүй, тэнд амьдардаг зэрлэг ан амьтдын хоол тэжээлийн бүс, амьдрах, оршин тогтнох цорын ганц орчин нь болж байдаг онцлогтой.


2.4.2. Газрын доорхи ус

Тухайн талбай нь дунд ба эртний төрмөлийн хурдасаас бүрдэх мегаантиклинори түүний бүрэлдэхүүнд багтах өргөргийн сунаж тогтсон Ноёны хотон бүтцийн зэргэлдээ байрлах тул дээрх атираат бүтцүүдийн байрлах гадаргын өндөршлөөс шалтгаалан сэвсгэр хурдас бүхэлдээ хуурайшсан байдаг. Гүний уст үеүд нь хур тунадасны ус болон гольдролуудын дагуух урсацын нэвчилтээр тэжээгдэж байдаг.

2.5. Хөрсөн бүрхэвч

“Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор байрлах нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний 12-р тойрогт хамрагдана. Энэхүү тойрогт нам уулс, толгодын хэсгээр эх чулуулгын илэрцтэй, дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал /гөлтгөнөгүй/, тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана [БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990].

Зураг 21. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг.



Тухайн нутаг дэвсгэрт цөлийн бор саарал хөрсний төрөлд багтах дараах төрлийн хөрс тархана. Үүнд:

- Эх чулуулгын илэрцтэй цөлийн бор саарал
- Цөлийн бор саарал
- Элсэн хучаастай далд глейрхэг цөлийн бор саарал
- Сайр чулуурхаг нимгэн цөлийн бор саарал
- гэсэн хөрс голлон тархсан байна.

Эх чулуулгын илэрцтэй цөлийн бор саарал хөрс. Энэ хөрс гадаргаасаа эхлээд нунтаг карбонатын хуримтлалтай, харин давсархаг шинж байхгүй. Зөвхөн занар чулуу, цэрдийн галавын алаг хурдас чулуулагтай газраар хөрсний доод хэсэгт давсны хуримтлал болон гөлтгөнө агуулагдсан байна.

Сайр чулуурхаг цөлийн бор саарал хөрс. Сайр чулуурхаг цөлийн бор саарал хөрс шүлтлэг, их шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж 0.4-0.5%-иас үл хэтэрнэ. Цөлийн хөрсний морфологийн гол шинж болох сүвэрхэг шинжтэй хальслаг өнгөн үе муу илэрч, харин улаавтар бор өнгөтэй, нягт тогтоцтой Vt_{ca} давхарга тод ажиглагдана. Түүний дээд талд үелсэн бүтэцтэй нимгэн үе заримдаа сайн мэдэгдэнэ. Сайр чулуу ихтэй учраас хөрсний үе давхаргууд тасалдаж алаг цоог шинжтэй байх тул нийт зузаан 20-25 см-ээс хэтрэхгүй байдаг.

Цөлийн бор саарал хөрс. Жинхэнэ цөлийн хөрс манай орны урд хэсгээр тархах ба сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамал зонхилсон цөлийн ургамалшил маш сийрэг тархай байдалтай, газрын гадаргын дөнгөж 5-10%-ийг бүрхэнэ.

Хөрс үүсгэгч эх чулуулаг нь голдуу пролюви, делюви-пролювийн гаралтай сайр чулуурхаг хөнгөн шавранцар, элсэнцэр хурдас байх тул хөрсний бүх үе давхарга сайр чулуутай. Ердийн нөхцөлд энэ хөрсөнд хялбар уусах давс, гөлтгөний хуримтлал үл ажиглагдах бөгөөд гагцхүү цэрд-палеогений давсархаг хурдас дээр тогтсон хөрсөнд гөлтгөнө, хялбар уусах давс, ялангуяа доод давхаргуудад нь нэлээд хэмжээтэй байна.

Ширхэгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс зонхилно. Ялзмагийн агууламж 0.2-0.5% орчим байх түүний хэмжээ мөн V_t , $V_{t_{ca}}$ давхаргад арай илүү байна. Хөрсөн дэх ялзмагийн бодисын нөөцийг тооцож үзэхэд 0-20 см үед 5-6 т/га орчим байна. Хөрсний бүх үе давхарга шүлтлэг орчинтой, шингээх багтаамж бага (100 гр хөрсөнд 8-12 мг-экв), шингээгдсэн сууриудын бүрэлдэхүүнд кальцийн катион зонхилж, солилцоот натри өчүүхэн хувийг эзэлнэ.


Цөлийн бор саарал хөрс дэд хэв шинжүүдэд хуваагдахгүй бөгөөд харин судалгааны нутаг дэвсгэрт ердийн, сайр чулуурхаг, мараалаг, сийрэг элсэн зэрэг төрлүүд элбэг тархана.

Элсэн хучаастай мараалаг цөлийн бор саарал хөрс - гуравдагчийн давсархаг улаан хурдас бүхий хотос, хонхор газраар тархах бөгөөд ургамлан нөмрөгт бор бударгана, улаан бударгана, баглуур голлож ургана. Доод үе давхарга нягт цулдам шинжтэй, самранцар-призм маягийн бүтэцтэй, шингээгдсэн натрийн агууламж багатай (100 гр хөрсөнд 0.4-2 мг-экв)-гаас гадна энэ хөрсөнд хялбар уусах давсны хуримтлал байхгүй мараалаг давхарга нь үлдмэл шинжтэй байна.

2.6. Ургамалан нөмрөг


Ханбогд сум нь байгаль ургамал газар зүйн тархацын мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар Евро-Азийн хээрийн мужийн Умард говийн цөлийн хээрийн провинцийн Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Цогтцэцийн район, Азийн цөлийн мужийн Умард говийн провинцийн: Алашаа говийн цөлийн тойргийн Галбын говийн районуудад хамаарна. Дорнод говийн цөлийн хээрийн тойрог. Ханбогд сумын Галбын говиос баруун ба зүүн хойт чигт үргэлжилсэн уудам хотгор нь Дорноговийн цөлийн хээр юм.

Зураг 22.. Ханбогд сумын ургамалжил



Сумын бэлчээрийн ургамалжилтын төрх байдал, доройтол. Сумын нийт нутаг дэвсгэрийн бэлчээрийн төрх байдлын 35.7 хувийг сөөгтэй бэлчээр, 27.3 хувийг чулуутай бэлчээр, 9.3 хувийг заган ойтой бэлчээр тус тус эзэлж байна.


Зураг 23. Бэлчээрийн төрх байдал



Эх үүсвэр.

Ургамлын амьдралын хэлбэр. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа 161 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 34 зүйл нэг ба хоёр наст өвслөг ургамал (21.1%), 75 зүйл олон наст өвслөг ургамал (46.6%), 45 зүйл сөөг, сөөгөнцөр ургамал (27.9%), 4 зүйл шарилж шимэгч ургамал (2.5%), 3 зүйл модлог ургамал (1.9%) бүртгэгдсэн байна.


Зураг 24. Ургамлын амьдралын хэлбэр



Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа бүх зүйл ургамлаас 25 овог, 87 төрлийн 127 зүйл бэлчээр тэжээлийн ач холбогдолтой ургамал (78.9%), 21 овог, 35 төрөл, 46 зүйлийн (28.6%), 10 овог, 24 төрлийн 34 зүйл (21.1%) ургаж байна.

Ханбогд сумын нутагт ургаж байгаа 11 зүйл нэн ховор, 13 зүйл ховор, 26 зүйл Монголын унаган ургамал (эндемик), 25 зүйл завсарын унаган ургамал, 11 зүйл үлдэц (реликт) ургамал ургаж байна.

Зураг 25. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал



Зураг 26. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай зүйлийн бүрдлийн бүтэц

Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэхувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	8	12	12	7.5%
Үлдэц ургамал	9	11	11	6.8%
Ховор ургамал	10	12	13	8.1%
Монголын унаган ургамал	10	22	26	16.1%
Монголд байгаа завсрын унаган ургамал	14	19	25	15.5%
Нийт				54.0%

Нэн ховор ургамлын ховордох шалтгаан. Судалгаанаас харахад ган, хэт хуурайшил, уулын үер, цөлжилт, салхи зэрэг байгаль цаг уурын нөлөөнөөс болж байгалийн жамаар нөхөн сэргэж ургах чадваргүй болох болон эмнэлэг, хүнс, түлш, малын бэлчээр, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг хүний хэрэглээний хүчин зүйлээс болж тархац нөөц хомсдон жилээс жилд улам ховордсоор улмаар устаж үгүй болох аюулд хүрэх магадлалтай юм.

2.7. Амьтны аймаг

Ханбогд сум түүний орчмын ан амьтад нь монгол орны амьтны газарзүйн хуваарилалт /зоогеографийн мужлал/ аар Уулархаг Азийн доод мужийн Монгол Түвдийн провинц, говийн дэд провинцийн хойд говийн тойрогт багтана. Хойд говийн тойргийн онцлог нь говийн бүсийн бүх нутгийг хамардаг учраас амьтны аймаг нь говийн ба зарим талаараа хээрийн амьтаас бүрддэг.

Махчин амьтадаас: өмхий хүрэн, хярс, үнэг зонхилдог.

Мэрэгч амьтадаас: Монгол даахай, хөх цомч, урт сүүлт шишүүхэй, туурайтнаас: хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг амьтад тохиолдож байна. Цаг агаарын урин дулаан, өвс ургамлын гарц зэргээс шалтгаалж сүүлийн жилүүдэд цагаан зээр хэсэг бусгаараа нүүдэллэн ирэх болсон байна. Монголын болон олон улсын улаан ном, конвенцэд орсон 5-6 зүйл тохиолдох боловч байнга нутагладаггүй.

Мөлхөгчдөөс: нохой гүрвэл (*Teratoscincus przewalskii*), цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*), говийн гүрвэл (*Eremias przewalskii*), могой гүрвэл (*Eremias multiocellata*), нарийн могой (*Coluber spinalis*), рашааны могой (*Elaphe dione*), сум могой

(*Psammophis lineolatus*), бамбай хоншоорт могой (*Agkistrodon halys*), тэмээн аалз (*Lycosa singoriensis*) зэрэг амьтад амьдардаг. Эдгээрээс зарим амьтадаас "Улаан ном"-д орсон тэмээн сүүлт могой, нарийн могой болно.

Зураг 27. Говийн амьтад



1. Хулан 2. Говийн чоно 3. Сум могой 4. Говийн гүрвэл

Шавьж

Манай гаригт орчин үед мэдэгдэж буй амьтдын дөрөвний гурваас илүү хувийг шавьж дангаараа эзэлнэ. Хөрс, ус, агаар төдийгүй ургамал амьтны бие эрхтэнд амьдардаг хамгийн их нягтшилтай амьтан бол шавьж юм. Одоогийн байдлаар дэлхийд 1.2 сая гаруй зүйл шавьж илрүүлээд байна. Эрдэмтдийн тооцоолж байгаагаас үзвэл энэ тоо нь манай дэлхийд орших шавжийн зүйлийн бүрэлдэхүүний бодит тооны 75 хувь болох юм. Монгол орон түүний дотроос Өмнөговь аймаг нь шавьжаар нэн баялаг бөгөөд эдгээр нутагт амьдрах шавжийн биологи, экологийн судалгаа нь зөвхөн зүйлийн бүрдлийг тогтоох чиглэлд хийгдэж байна.

2.8. Нийгэм, эдийн засгийн төлөв байдал

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор нь Ханбогд сумын Жавхлант багийн нутагт байрлана. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 130 км, аймгийн төвөөс 252 км, нийслэл Улаанбаатар хотоос 600 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-тай, баруун талаараа БаянОвоо, хойд талаараа Манлай, Цогтцэций сумд, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг сумтай хил залгана. 1515.1 км² нутаг дэвсгэртэй. Тус суманд зэс, алт, төмрийн орд байхаас гадна дэлхийд ховор армоострон болон Монголит гэдэг газрын ховор элементүүд, барилгын материал, палеонтологийн олдвороор элбэг юм.

Хүн ам, өрхийн тоо: Ханбогд сум нь Номгон, Гавшууд, Жавхлант, Баян, Хайрхан гэсэн 5 багтай. 2022 оны байдлаар 8533 хүн ам, 2116 айл өрх бүртгэгдсэн байна.

Хүснэгт 6. Ханбогд сумын хүн ам, өрхийн тоо

№	Багууд нэр	Хүн амын тоо	Өрхийн тоо
1	Номгон	1155	325
2	Гавшууд	1581	516
3	Жавхлант	2772	615
4	Баян	2217	550
5	Хайрхан	538	110

Боловсрол: Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуульд 1-р ангид элсэгчдийн тоо 108, 12-р анги төгсгөчдийн тоо 45 байна. Ханбогд сумын нийт элсэгчид, төгсгөчдийн тооноос харахад элсэгчдын тооны хувьд харьцангуй бага хэлбэлзэлтэй жигд байхад төгсгөчдийн тоо хэлбэлзэл ихтэй, маш бага буюу 21 хүүхэд 11-р ангиа төгссөн үзүүлэлт байна.

Эрүүл мэнд: Сумын эрүүл мэндийн байгууллагад 14 их эмч, 6 бага эмч, 11 сувилагч, 2 эмийн санч тус тус ажиллаж байна.

Ажил эрхлэлт: Ханбогд сумын хэмжээнд 282 иргэн ажил хайж байгаагаас 142 иргэн нь идэвхтэй ажил хайгч байна. Иймээс иргэдээ ажилтай орлоготой байлгах зорилгоор Уул уурхайн компаниудын ажилчдын 50-аас доошгүй хувь нь орон нутгийн иргэн байх гэсэн үндсэн шаардлагыг тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Ханбогд сумаас Оюу толгой ХХК болон туслан гүйцэтгэгч компаниудад нийт 1632 иргэн ажиллаж байна. Ханбогд сумын хувьд хөдөлмөрийн насны 4810 иргэн байгаагаас төрийн албанд 435, уул уурхайд 1632, жижиг дунд үйлдвэрлэлт эрхлэгчид 27, малчид 1126 байна.

Эдийн засгийн байдал

Монгол улсад нийт бүртгэлтэй 113602 аж ахуйн нэгж, байгууллагын 1.5 хувь, төвийн бүсийн 15.2 хувийг Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Өмнөговь аймаг Монгол улсын ДНБ-ийн 2.6 хувь, төвийн бүсийн 21.2 хувь болох 574.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн нэг хүнд ногдох ДНБ 9.6 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хотын дараа 3-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 36.6 тэрбум хүрч Улаанбаатар, Орхон аймгийн дараа 3-т тус тус орж байна.

ХАА-н үзүүлэлт

Мал аж ахуй: 2014 оны эцэст 5216 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 43 өрхөөр өссөн байна. Аймгийн хэмжээнд 183-н мянгат малчинтай болж 2000-с дээш мал тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Ханбогд сум 22655, адуугаар Манлай сум 8176, үхрээр Ханбогд сум 3386, хониор Ханхонгор сум 41528, ямаагаар Номгон сум 171900 толгойгоор тус тус тэргүүлж байна.

Газар тариалан: Аймгийн хэмжээнд 2014 онд 9625.9 тн хадлан, 36.6 тн таримал тэжээл, 726.5 тн гар тэжээл, 14.5 тн даршны ургамал 2771.6 тн хужир шүү, 81.8 тн төмс, ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Нэг. Агаар орчин			
1.	Тоосжилт	Тээвэрлэлт (ахуйн хэрэгцээний бүх төрлийн хангамж, түлш, хог хаягдал)	Тархах хүрээ хомс, сайжруулсан шороон замаар төслийн талбай хүрдэг
2.	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаар	Автомашин	Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Усан орчин			
1.	Хатуу болон шингэн хог хаягдал	Ахуйн болон шатах тослох материалын хаягдал Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих	Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.
Гурав. Хөрс			
1.	Элэгдэл, эвдрэл	Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	Хэмжээ хязгаарлагдмал Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно Хөрс эвдэрч элэгдэнэ Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой
2.	Бохирдол	Ахуйн хог хаягдал	Хөрс бохирдосноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө
Дөрөв. Ургамал бүрхэвч			
1.	Ургамлын талхлагдал	Автомашин болон явган хүний зам, мөр	Хэмжээ хязгаарлагдмал
2.	Ургамлын нөмрөг устгах	Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй устгах	Төрөл, зүйл өөрчлөгдөж болно Төрөл, зүйл устаж болно Хэмжээ хязгаарлагдмал
3.	Хордолт	Ахуйн хог болон шатах тослох материалын хаягадал	Ургамлын биомассын хэмжээ багасна Ургамал бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.	Талхлагдах	Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зэрэг зам, жим гарах	Ургамлын төрөл зүйл устаж болно Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно
Тав. Ан амьтан			
1.	Хордолт	Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай
Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин			
1.	Үндсэн хөрөнгө	Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулах
2.	Шинээр ажиллагсад авна	Ажлын байр шинээр бий болно	Орон нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ Тогтмол бус

Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газар доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x			x					
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл эвдрэл	x				x				x	
Геологийн тогтоцын өөрчлөлт										
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		X		X						X
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал	X				X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	X				X	X		x		
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	X		X	X						X
Хөрсний эвдрэл, бохирдол	X				X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө		X								x
4. Байгалийн өнгө төрх, түүх дурсгалын зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх		X			X					x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйл нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X				X					x
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X						X
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		X		X						X
Ажлын байр нэмэгдэх	X			X						X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X			X					X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх										
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X			X			X		X	
Ахуйн бохир ус, нефтийн	X						X		X	

бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс бохирдуулах										
Ахуйн хаягдл, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X			X		X			x	
Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга	X			X			X	X		
Дүн	14	6	1	10	8	2	7	3	8	9

Хүснэгт 9. Төслийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1.Төслийн байршилтай холбогдон гарах нөлөөлөл					
1.	Хүн ам нүүлгэн шилжүүлэх асуудал	0			
2.	Тусгай хамгаалалттай бүх нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчин	0			
3.	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
4.	Ой модыг огтлох, гэмтээх асуудал	0			
5.	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	0			
6.	Булаг шандны усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх	0			
7.	Голын гольдирол эвдэж өөрчлөх эсэх	0			
8.	Байгалийн эрдэс баялгийг ашиглах эсэх				
2.Төслийн шийдэлтэй холбогдол бүхий нөлөөлөл					
9.	Үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эмэх	+	+		
10.	Төслийн үйл ажиллагаанд тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, бодис хэрэглэх эсэх	0			
11.	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл, түүний эд нь байгаль орчинд хэр нийцтэй эсэх	+	+		
3.төслийн үйл ажиллагааны холбогдол бүхий нөлөөлөл					
12.	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын талаарх төлөвлөгөө, санхүүжилт, хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх	+	+		
13.	Хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах орчныг тохижуулах төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан эсэх	+			+
14.	Төслийн үйл ажиллагааны нөлөөллөөр хөрс, ургамал талхлагдах эсэх	-	-		
15.	Төслийн байгууламж хоорондын хөрсний бохирдлыг багасгах талаар төлөвлөгөөнд тусгагдсан эсэх	+	+		
16.	Төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх	+	+		
17.	Ядуурлыг бууруулах	+	+		
18.	Эдийн засгийн өсөлт	+	+		
19.	Онцгой нөлөөлөл	0			

Хүснэгт 10. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1.	Ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын устгал хөрсөнд шингэх	Орчны хөрс, хөрсний ус	-	Боломж бага	Хавар, намар, зуны улиралд
2.	Зам, жим харгуй ихсэх	Хөрс, ургамал	Агуулахын ойр орчим	Их	Төслийн түвшинд
3.	Тээврийн хөдөлгөөн ихсэх	Орчны ургамал нөмрөг, хөрс	-	Их	Тогтоох боломжгүй
4.	Түймэр	Хүн, мал, эд хогшил, ургамал, ой, хөрс	-	Хүчтэй	Тогтоох боломжгүй

Хүснэгт 11. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Химийн бодисын хоруу чанараас	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
	<ul style="list-style-type: none"> - Арьс, нүд, хамар хоолойг цочроох - Залгихад хортой, урагт нөлөөлж болзошгүй - Удаан амьсгалвал амьсгалын замын эрхтэн системийг гэмтээж болзошгүй 	<ul style="list-style-type: none"> - Усан орчинд нөлөөлөл үзүүлэх - Усны амьтдад нөлөөлөх - Усан орчны организмд удаан хугацаагаар нөлөөлнө
	<ul style="list-style-type: none"> - Ажиллагсад химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгарах, нүдэнд хүрэлцэн цочроох, хурц болон ужиг архаг хордлого зэрэг эрсдэл үүсч болзошгүй 	<ul style="list-style-type: none"> - Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол аюулын улмаас химийн бодис уурших замаар агаар, хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, орчинд тархах
Агуулахын үйл ажиллагаанаас	<ul style="list-style-type: none"> - Төслийн үйл ажиллагааны явцад ажиллагсдын анхаарал болгоомжгүй үйл ажиллагааны улмаас бодис асгарах улмаар галын аюул үүсвэл шаталтын дүнд хорт хий ялгаруулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй - Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс дээрх эрсдэл үүсч болзошгүй 	<ul style="list-style-type: none"> - Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлуулж, устгаагүй, ил задгай хаях зэргээс байгаль орчинд бохирдол үүсч болзошгүй - Агаарт эвгүй үнэр тархах болон хийн бохирдол үүсгэх

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны (тухайн жилийн) байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага (Байгаль орчин, аялал жуулчлалын яам) тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр

сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч						
Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис асгарч алдагдах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд тухайн орчны газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох	Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис асгарч алдагдах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд байршуулж, ажилчдад ашиглах дадлыг эзэмшүүлэх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд		500,000	2023 он	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас-ерөнхий шаардлага
Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлыг ил задгай хаясны улмаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодлыг импортлогч руу нь буцаах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд	-	Урьдчилан тооцох боломжгүй.	2023 он	Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, БОАЖ-ын сайд, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт Хог хаягдлын тухай хууль,

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
						40.5 дугаар зүйл
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын талбайн болон орчны бүсэд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.		2 удаа	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850: 2019
	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг хуулинд заасан хугацаанд хийлгэх	“Орика монголиа” ХХК	Дотоод төлөвлөлтөөр		5 жилд нэг удаа	Газрын тухай хуулийн 58-р зүйл Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
Тэсрэх болон химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдон гарах нөлөөлөл	Бүх төрлийн тэсрэх болон химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд	Үйл ажиллагааны туршид			“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” – Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал
Агаарын чанар						
Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн	Агааржуулалтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд		200,000	2023 он	MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис асгарч алдагдах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд тухайн орчны агаарын чанарт нөлөөлж болзошгүй.	Тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг бүрдүүлсэн байх, уурших, халах нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд	-	Дотоод төлөвлөлтийн зардалд тусгах	2023 он	Ерөнхий шаардлага
Авто машин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд	Дотоод хяналтаар		Тогтмол	MNS 0017-5-1-21: 1992 Дуу, чимээ. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх төвшин, хэмжих арга
Усны нөөц, чанар						
Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол, санамсар болгоомжгүй байдлаас химийн бодис хөрсөнд алдагдсан тохиолдолд хөрс бохирдож усны чанарт нөлөөлж болзошгүй.	Асгарсан тэсрэх болон химийн бодисыг борооны ус дамжуулах хоолой, бохир ус зайлуулах системд орохоос урьдчилан сэргийлсэн байх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын талбай орчимд	-	Дотоод төлөвлөлт зардалд тусгах	2023 он	MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
Ажилчдын эрүүл мэнд						

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчигдөх, гэнэтийн осол гарах, тэсэрч дэлбэрэх тохиолдолд тухайн орчинд ажилладаг ажилчид осолд өртөх, тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ажилтнууддаа ХХАА-ны дүрэм журам, химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харилцах, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх, эрсдэл, аюул, ослын үед авах арга хэмжээ, ослыг хэрхэн мэдээлж, тусламж дуудах талаар сургалтыг тогтсон хугацаанд зохион байгуулж зохих мэдлэг, дадлыг эзэмшүүлэх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын ажилчид		200,000	2023 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
	Ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах (хамгаалалтын гутал, хувцас, малгай, нүдний шил, бээлий, нүүрний баг, амьсгал хамгаалах баг), аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулахын ажилчид	-	Зардлыг осол, эрсдэлийн менежмент ийн төлөвлөгөө нд тусгав.	2023 он	MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Аврах зам, гарц, цугларах цэг, анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, чиглэлийн заасан тэмдэглэгээг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулах	-		2023 он	MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг
	Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, хадгалах агуулах	-		2023 он	
Нийт, төг				900,000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгаль, цаг уурын онцлогт тохируулан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын тээвэрлэлтийн зам дагуу мод тарьж хамгаалалтын ойн зурвас байгуулна.	Мод тарих /хайлаас, буйлс, улиас/	1,5 км зам дагуу	ширхэг	Жилд 300 ширхэг мод тариж замын хамгаалалтын ойн зурвас байгуулна.	1 суулгацын дундаж үнэ 6000 төгрөг**	1800,0	2023 оны 5,10 дугаар сар	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл.
Нийт						1800,0		

** huree.mn/модны-суулгацын-үнэ-ханш-2022/

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)

Хүснэгт 14. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн бодис асгарах	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материал (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс г.м), хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг ажлын талбарт бэлэн байлгах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор	-		2023 он	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт
Байгалийн гамшигт үзэгдэл, гэнэтийн осол болох, гал гарах, дэлбэрэлт болох	Ээлж бүрээс нэг ажилтаныг ХХАА-ны дүрэм журам, химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харилцах, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх, эрсдэл, аюул, ослын үед авах арга хэмжээ, ослыг хэрхэн мэдээлж, тусламж дуудах болон онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны талаар сургалтад хамруулах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын ажилчид	-	2,500,000	2023 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах (хамгаалалтын гутал, малгай, нүдний шил, бээлий, нүүрний баг, амьсгал хамгаалах баг), аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын ажилчид	-	1,500,000	2023 он	MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
	Аврах зам, гарц, цугларах цэг, анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, чиглэлийн заасан тэмдэглэгээг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор		500,000	2023 он	MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг
	Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах					
	Хориглох тэмдгийг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах					
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатай газарт тэмдэглэгээг байрлуулах					
	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборт орж буй хүмүүсийг гал гаргах, тамхи татахыг хатуу хориглож хяналт тавих, тэмдэг тэмдэглэгээ хийх	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023 он	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS 4244:1994 Хөдөлмөр хамгаалалын систем Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага MNS 5566:2005. Аж ахуй нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж
	Болзошгүй гал түймрийн үед ашиглах усан сан, гал эсэргүүцэх галын хор, элс, шат, хувин, лоом, хүрз, зээтүү бүхий иж бүрэн галын					

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	сарайтай байх					хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
Нийт, төг				4,500,000		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023ОН)

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал нь аюултай хог хаягдлын ангилалд багтах бөгөөд 2020 оны 2 дугаар сарын 11-нд аюултай хог хаягдал боловсруулах эрх бүхий “Цэцүүх трейд” ХХК-тай “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”¹ байгуулсан. Тус гэрээнд хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэйгээр шилжүүлэх ба аюултай хог хаягдлын тоо хэмжээг жилд нийт 520 орчим тн байна гэж тодорхойлсон ба тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий ААН-ийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэхээр заасан байна. Энэ гэрээгээр үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Налайх дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт орших “Цэцүүх ПЕ&ПП дахин боловсруулах үйлдвэр”-т хүргэнэ.

Хүснэгт 15. Үүсэх хог хаягдлын химийн бодисын жагсаалт

№	Тухайн сав баглаанд агуулагдаж байгаа бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл
1	Аммонийн нитрат	Ammonium nitrate
2	Цууны хүчил	Acetic Acid
3	Тиомочевин	Thiourea
4	Натрийн карбонат	Sodium carbonate
5	Эмульсжүүлэгч SB 120i	Emulsifier SB 120i
6	Эмульсжүүлэгч FBHP90	Emulsifier FBHP Surfactant blend
7	Парафин тос	Paraffin oil
8	Натрийн нитрит	Sodium nitrite
9	Этилен гликоль	Ethylene Glycol
10	Будагч бодис	Brilliant Blue FCF

Дараах хүснэгтэд жилд үүсэх аюултай хог хаягдлын хэмжээг үзүүлэв.

Хүснэгт 16. Аюултай хог хаягдлын жилд үүсэх хэмжээ

№	Тухайн сав баглаанд агуулагдаж байгаа бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ				Нийт
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	
1	Аммонийн нитрат	Шуудай	10 тн	10 тн	10 тн	10 тн	40 тн
2	Эмульсжүүлэгч SB 120i	Химийн хуванцар IBC танк	80 ш	80 ш	80 ш	80 ш	320 ш
3	Эмульсжүүлэгч FBHP90	Химийн хуванцар IBC танк	40 ш	40 ш	40 ш	40 ш	160 ш

БОАЖ-ын сайд, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар хамтарсан тушаалаар “Үүсэх хог, хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах бүтээгдэхүүний жагсаалт”-ыг баталсан. Дараах үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргэн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

¹ Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ.

1. Хуванцар сав суулга, түүхий эд;
2. Нийлэг уут, түүний түүхий эд;
3. Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор;
4. Хими цэвэрлэгээний бодис;
5. Шилэн лонх, сав;
6. Өндөр даралтат сав;
7. Химийн хортой болон аюултай бодисын сав, баглаа боодол;
8. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, дугуй;
9. Мөнгөн ус агуулсан бараа бүтээгдэхүүн;
10. Аюултай хог хаягдал.

Хэрэв төсөл хэрэгжүүлэгч нь химийн бодис, материалуудыг химийн бодис худалдаалах тусгай зөвшөөрөл бүхий дотоодын аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авах тохиолдолд дээрх жагсаалтын 6, 7, 10-д нэр дурдагдсан хог, хаягдлуудыг ханган нийлүүлэгчид буцаан нийлүүлэх боломжтой.

Дээрх төрлийн хог, хаягдлыг дахин боловсруулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, холбоо барих утсыг доор үзүүлэв.

Хүснэгт 17. Химийн аюултай, хортой бодисын хуванцар сав, полипропилен уут, шуудай, баглаа боодлыг дахин боловсруулах байгууллагын мэдээлэл

Аж ахуйн нэгж, байгууллага	Үйл ажиллагааны чиглэл
<p>“Цэцүүх трейд” ХХК Утас: 99057708</p>	<p>Химийн аюултай, хортой бодисын хуванцар сав дахин боловсруулах PE-полиэтилен, PP-полипропилен дахин боловсруулах эко үйлдвэр юм. Химийн бодисын ашиглагдсан полиэтилен канистр, торх, ИВС танк, полипропилен уут, шуудай, баглаа боодлыг дахин боловсруулж хуванцар үрлэн түүхий эд үйлдвэрлэнэ.</p>

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн зэрэг шаардлагуудыг хангасан хогийн савыг тус агуулахын хог хаягдал хамгийн их үүсдэг хэсгүүдэд байршуулах шаардлагатай. Хогийн саванд цугларсан хогны ангилалыг дахин шалгаж хог хаягдал түр хадгалах цэгт хадгална. Багахангай дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулсан. “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ыг баримталж ажиллана.

Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<p>Энгийн хатуу хог хаягдлыг ил задгай хаях, салхиар тухайн орчинд тархах, шаардлага хангасан саванд хийхгүй байх, тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс тухайн орчинд бохирдол үүсэх</p>	<p>Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн зэрэг шаардлагуудыг хангасан хогийн савыг байрлуулж, Багахангай дүүргийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний дагуу тогтсон хугацаанд хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулж байх</p>	<p>Гэрээний нөхцөл дээр үндэслэн зардал өөрчлөгдөх боломжтой.</p>	<p>500,000</p>	<p>2023 он</p>	<p>Хог хаягдлын тухай хууль</p> <p>Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага, БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт</p> <p>MNS 5924 : 2015 (Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага)</p>
<p>Химийн бодисын сав баглаа боодол санамсаргүй байдлаар ахуйн хог хаягдалтай цуг хаягдах</p> <p>Шингэн хаягдал, химийн бодисын үлдэгдэл алдагдах</p>	<p>Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23.1-д заасан хугацаанд эх үүсвэр дээр ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж, агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд түр хадгална.</p> <p>Аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл ийм материалаар доторлосон байх</p> <p>Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн</p>			<p>2023 он</p>	<p>Хог хаягдлын тухай хууль</p> <p>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт</p> <p>Үүсэх хог, хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах бүтээгдэхүүний жагсаалт, БОАЖ-ын сайд, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар хамтарсан</p>

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	<p>хугацааг тэмдэглэсэн байна.</p> <p>Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах болон устгах зөвшөөрөлтэй компанид нийлүүлэх</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодлыг боломжтой бол импортлогч руу нь буцаах</p>		3,000,000		тушаал
	<p>Ажилтнууддаа хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх</p>	-	ОЭМ төлөвлөгөөний зардалд тусгав.	2023 он	
Нийт			3,500,000		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутагт хэрэгжих “Эмульсийн тэсрэх бодис, агуулахын цогцолбор төсөл”-ийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны бүрдэл хэсгүүдийг тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, аргачлал	Дээд, доод хязгаар
Агаарын чанар							
- Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) - Хүхэрлэг хий (SO ₂) - Азотын давхар исэл (NO ₂) - Тоосонцор (PM _{2.5} ;10) - Дотоод орчин: - Температур - Чийгшил - Гэрэлтүүлэг - Агаарын урсгалын хурд	мкг/м ³	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор гадаад ба дотоод орчноос	Жилд 2 удаа /2-3 цэг/ 5, 10 сар		1,000,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 6767:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага	
Хөрсөн бүрхэвч							
- Хүнд металл, ерөнхий хими шинжилгээ	мг/кг	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор хашаанд	Жилд 2 удаа 5,10 сар	100,000	200,000	MNS 2305:1994 (Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам) MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
-Ерөнхий хими, Аммони, E-coli бактери		Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлын цэг орчмоос		100,000	300,000		
- Хүнд металл, ерөнхий хими шинжилгээ		Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах цогцолборын талбайн гадна		100,000	200,000		
Нийт, төг					1,700,000		

**АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хүснэгт 20. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			сар	сар	сар		
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх	2,500,000		6		Ерөнхий менежер	Мэргэжлийн байгууллагатай тохиролцсон гэрээнд тулгуурлан мөнгөн дүн өөрчлөгдөх боломжтой.
2	Байгаль орчны аудит хийлгэх	4,000,000			8	Ерөнхий менежер	
	Нийт	6,500,000					

**АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)**

**Хүснэгт 21. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад
тайлагнах хуваарь**

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах газар
БОАЖЯ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлнэ.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэл	2023 оны 11 дүгээр сарын 20-ний дотор		БОАЖЯ
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хүргүүлж, санал авах	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайлан	2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор		
Ханбогд сумын Жавхлант багийн иргэд	Иргэдэд энэхүү төслийн тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	-Төслийн танилцуулга - Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ - Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт	2023 оны 9-10 дугаар сар	500,000	Ханбогд сумын Жавхлант багийн иргэдийн хурлын танхим
Нийт				500,000	

Хүснэгт 22.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Зардлын төрөл	Тухайн жилийн зардал, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	10700,0
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	900,0
	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1800,0
	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4500,0
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3500,0
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1700,0
	Агаарын чанар	1000,0
Хөрсөн бүрхэвч	700,0	3
3	Удирдлага зохион байгуулалт	6500,0
4	Төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах	500,0
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		19400,0